



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 09 сарын 20 өдөр

Дугаар 88

Сүхбаатар сум

**“Жимс, жимсгэнэ” аймгийн хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ын “з”, 19 дүгээр зүйлийн 19.1, Монгол Улсын Тариалангийн тухай хуулийн 22.1, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 дүгээр бүлгийн 1.1.8 дахь зорилтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Жимс, жимсгэнэ” аймгийн хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан, хөтөлбөрийн биелэлтийн явцыг 2 жил тутамд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Ш.Оргил/-д даалгасугай.

ДАРГАС Г.БЯМБАА



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2018 оны 09 дүгээр сарын  
20-ны өдрийн 83 дугаар тогтоолын хавсралт

**“ЖИМС, ЖИМСГЭНЭ” АЙМГИЙН ХӨТӨЛБӨР**

**Жимс, жимсгэний хэрэглээ, өнөөгийн байдал**

Жимс, жимсгэнэ нь хүний биед зайлшгүй хэрэгцээт амин дэм, сахар, эрдсийн элемент болон биологийн идэвхит бодисоор баялаг хүнсний чухал бүтээгдэхүүн төдийгүй бут сөөг нь ойн зурвас, ногоон байгууламж байгуулах замаар хөрс хамгаалах, уур амьсгалыг зөөлрүүлэх, элсний нүүдлийг зогсооход хамгаалалт болдог олон талын ашиг тустай.

Манай орны байгаль, цаг уурын нөхцөлд зохицсон 60 гаруй зүйлийн байгалийн жимс, жимсгэнэ ургадгаас манай аймагт 10 гаруй зүйлийн жимс ургаж байна.

Насанд хүрсэн хүн жилд дунджаар 65.7 кг, өдөрт 180 гр жимс, жимсгэнэ хэрэглэх нь зохистой гэж үздэг. Манай аймагт нэг хүн 2000 онд 12 кг жимс, жимсгэнэ хэрэглэж байсан бол 2010 онд 9.5 кг болж буурсан бөгөөд 2017 онд 10,3 кг болж 0,8 кг-р нэмэгдсэн байна. Гэвч энэ нь аймгийн хүн амын физиологийн хэрэгцээт жимсний 15,7 хувийг хангаж байна. Улсын хэмжээнд жил бүр 18-22 мянган тонн жимс, жимсгэнийг импортоор авч байна.

Аймгийн хэмжээнд 2012-2016 онуудад “Чацаргана” аймгийн дэд хөтөлбөрийг дунд хугацааны 4 жилийн стратеги төлөвлөгөөтэй хэрэгжүүлснээр 702 га чацаргана, 57,1 га үхрийн нүд, 13 га алим, 2,4 га чавга, интоор, 19,3 га-д бусад жимс нийт 794,2 га жимс жимсгэнэ тариалж, нийтдээ 950,7 тн жимсний ургац бэлтгэж байгаагаас 150 гаруй тн нь таримал жимс, жимсгэний ургацаас бүрэлдэж байна.

**Нэг.Хөтөлбөр боловсруулах үндэслэл**

Жимс, жимсгэний үйлдвэрлэл нь олон жилийн уйгагүй хөдөлмөр, хөрөнгө санхүүжилт, туршлага, ур чадвар шаарддаг бөгөөд төр засгаас тууштай, урт хугацааны тогтвортой дэмжлэг үзүүлж байж үр дүнд хүрдэг онцлогтой.

Шинжлэх ухааны үндэслэлтэй олон төрлийн жимс, жимсгэнийг тариалж нутагшуулах, үрслэг үржүүлэх, шинэ сорт гаргах, үйлдвэрлэлийн аргаар боловсруулах чиглэлээр эрдэмтэд, судлаачид ихээхэн чармайлт гаргаж арга зүйг боловсруулсан байгаа нь үйлдвэрлэлт өргөнөөр нэвтрүүлэх нөхцөл бүрдсэн байна.

Энэхүү хөтөлбөр, таримлын болон бүтээгдэхүүний нэр төрөл, чанар, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, Олон Улсын чанар, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүний өртгийн сүлжээг хөгжүүлэх замаар өрсөлдөх чадварыг сайжруулан дотоод, гадаад зах зээлд өсөн нэмэгдэж байгаа жимс, жимсгэний эрэлт хэрэгцээг тогтвортой хангах, ажлын байр нэмэгдүүлэх, экспортод чиглэсэн, өрхийн болон аж ахуйн нэгжийн орлогыг өсгөх, хүн амын хүнсэн дэх жимс, жимсгэний хангамжийг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.40-д “Жимс, жимсгэний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, чацарганы үйлдвэрлэлийн нэгдсэн сүлжээ байгуулан, хүн амыг амин дэм бүхий жимс, жимсгэнээр ханган, экспортын орлогыг нэмэгдүүлнэ”, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.8.-д “Жимс, жимсгэний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, чацарганы үйлдвэрлэлийн нэгдсэн сүлжээ байгуулан, хүн амыг амин дэм бүхий жимс, жимсгэнээр ханган экспортын орлогыг нэмэгдүүлнэ” гэж заасан нь энэхүү хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болж байна.

#### **Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ ногоон эдийн засгийн үзэл баримтлалд тулгуурлан дараах зарчмыг баримтална.

- Гарал үүсэл нь тодорхой бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын аль ч дамжлагад стандарт,эрүүл ахуйн шаардлагыг чанд баримтлах.
- Экспортын баримжаатай экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэн тэргүүнд дэмжих.
- Байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалан, техник, технологийн дэвшил, шинжлэх ухааны ололтыг ашиглах;

#### **Гурав. Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь жимс, жимсгэний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн тариалалтыг 13 хувь буюу 900 га талбайд хүргэж, хүн амыг экологийн цэвэр, амин дэм бүхий жимс, жимсгэнээр тогтвортой хангах, импортыг бууруулах, өрсөлдөх чадварыг сайжруулан экспортын орлогыг нэмэгдүүлэхэд оршино.

#### **Дөрөв. Хөтөлбөрийн зорилт**

4.1. Хөтөлбөрийн хүрээнд дараахь зорилтуудыг хэрэгжүүлнэ.

4.1.1.Жимс, жимсгэний аж ахуйг хөгжүүлэх, таримлын болон бүтээгдэхүүний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах бизнесийн таатай орчинг бүрдүүлэх

4.1.2.Жимс, жимсгэний таримлын нутагшсан сортыг бий болгох, суулгац үйлдвэрлэлийг бүсчлэн хөгжүүлж, ган, хүйтэн, өвчин хортонд тэсвэртэй суулгацын хангамжийг нэмэгдүүлэх;

4.1.3.Жимс, жимсгэний тариалалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг инноваци, дэвшилтэт техник, технологи, шинжлэх ухааны судалгаанд суурилуулан цогц байдлаар хөгжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах;

4.1.4.Салбарын маркетингийн стратегийг боловсруулж, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг тодорхойлох, шинэ зах зээлд нэвтрэх ажлыг эхлүүлэх;

#### **Тав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ**

**5.1.“Жимс, жимсгэний аж ахуйг хөгжүүлэх, таримлын болон бүтээгдэхүүний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах бизнесийн таатай орчинг бүрдүүлэх” зорилтын хүрээнд:**

5.1.1.Жимс, жимсгэнэ тариалах, хураах, хадгалах, боловсруулах үйлдвэр байгуулах, шинэ техник, технологи, инноваци нэвтрүүлэхэд санхүү, хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжлэг үзүүлэх, санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх;

5.1.2.Жимс, жимсгэний талбайг хашаажуулах, ойн зурвас байгуулах, усралтын систем шинээр байгуулах, орчин үеийн дуслын усалгааны тоног төхөөрөмж суурилуулах, тариалалт, хөрс боловсруулалт, хураалтыг механикжуулах, суулгац худалдан авах иргэд, аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх;

5.1.3.Жимс, жимсгэний сортыг хянан баталгаажуулж, хяналт тавин мөрдүүлэх;

5.1.4.Жимс, жимсгэнэ тариалж шинээр ажлын байр бий болгосон иргэдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл, хөтөлбөр, зээлд хамрагдахад дэмжлэг үзүүлэх, тэдний мэдлэг, ур чадварыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах;

5.1.5. Жимс, жимсгэний өртгийн сүлжээг хөгжүүлэх, түүний байршил, хамрах хүрээ, үе шат, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан дэд бүтэц, жижиг, дунд үйлдвэрийн хөгжилтэй уялдуулан хэрэгжүүлэх;

5.1.6.Бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа, худалдааны дэвшилтэт арга, хамтын ажиллагааг хөгжүүлж, тогтвортой нийлүүлэлтийн сүлжээг үүсгэх, түүнийг орон нутгийн нөөцөд түшиглэсэн кластер болгон хөгжүүлэх;

5.1.7.Шинэ технологийг хөгжүүлэх, шинэ бүтээгдэхүүн (хөлдөөсөн, хатаасан, нөөшилсөн, нунтаг, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн зэрэг) болон шинэ сорт гаргах, усалгаажуулах, хураах технологийг сайжруулах, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;

5.1.8.Жимс, жимсгэний тариалалтын талбайг тордох, хөрсний үржил шимийг сайжруулах замаар үр өгөөжийг нэмэгдүүлэх, хамгаалалтын ойн зурвас байгуулах, гэр хорооллын өөрийн өмчлөлийн хашаандаа жимсний мод бут, тэр дундаа чацаргана тариалах иргэдийг дэмжих;

5.1.9.Хүнсний аюулгүй байдалд нийцсэн жимс, жимсгэний бүтээгдэхүүний сав, баглаа боодол, шошгыг стандартад нийцүүлэн мөрдүүлэх.

**6.2.“Жимс, жимсгэний таримлын нутагшсан сортыг бий болгох, суулгац үйлдвэрлэлийг бүсчлэн хөгжүүлж, ган, хүйтэн, өвчин хортонд тэсвэртэй суулгацын хангамжийг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд:**

6.2.1.Жимс, жимсгэний төрөл, зүйлийн сорт нутагшуулах, бойжуулга, суулгац үйлдвэрлэлийг эрчимжүүлэх

6.2.2.Алим, чавга, интоор, чацаргана, үхрийн нүд, нэрс, гүзээлзгэнэ, бөөрөлзгөнө, хад зэрэг жимс, жимсгэний сортын суулгацын ил талбайн болон хүлэмжийн эх цэцэрлэг, үржүүлгийн загвар аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн бэлтгэсэн суулгацыг жимс, жимсгэнэ тариалах иргэн, аж ахуйн нэгжид тодорхой хувийн хөнгөлөлттэй үнээр болон урт хугацаатай зээлээр олгох нөхцлийг бүрдүүлэх

6.2.3.Байгалийн жимс, жимсгэний нэр төрөл, тархалт, нөөцийн судалгааг хийж тарималжуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулан үйлдвэрлэлд нийлүүлэх боломжийг бий болгох

**6.3.“Жимс, жимсгэний тариалалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг инноваци, дэвшилтэт техник, технологи, шинжлэх ухааны судалгаанд суурилуулан цогц байдлаар хөгжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах” зорилтын хүрээнд:**

6.3.1.Технологид суурилсан хамгаалагдсан хөрсний аж ахуйг хөгжүүлж, дулаан нөхцөл шаарддаг усан үзэм, тоор, лийр, нимбэг, гүзээлзгэнэ, анар, улаан чавга зэрэг жимс, жимсгэнийг нутагшуулах

6.3.2.Жимс, жимсгэний тариалалт, хураалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлд хадгалалтын технологийг хөрс, бордоо, ургамал хамгаалал, сортын суулгац үржүүлэг, усжуулалт, механикжуулалт, хадгалалт, тээвэрлэлтийг цогцоор нь хөгжүүлэх;

6.3.3.Жимс, жимсгэнийг хүнсний нэмэлт бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэх, тосболовсруулах, жимс, навч, мөчир, холтсыг бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ашиглах туршилт явуулах, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи туршин үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

6.3.4.Жимс, жимсгэний үйлдвэрлэлд хүнсний чанар, аюулгүй байдлыг хангах бодлогын хүрээнд түүхий эд, бүтээгдэхүүнд хүнсний пестицидийн үлдэгдэл, өвчин хортонтой тэмцэх хүний нөөцийн чадавхжуулах сургалтуудыг зохион байгуулах;

6.3.5.Жимс, жимсгэний талбайд хамгаалах ойн зурвасыг байгуулж, тариалах агротехнологийг боловсруулах, тэдгээрийг хэвшүүлэх;

6.3.6.Байгаль цаг уурын нөхцөл ойролцоо хөрш орны жимс, жимсгэний судалгаа, шинжилгээ, үйлдвэрлэл эрхэлж байгаа байгууллага, аж ахуйн нэгж болон салбарын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч олон улсын байгууллагатай холбоо тогтоох, хамтын ажиллагааг өргөжүүлэх;

6.3.7.Өөрийн орны онцлогт тохирсон жимс, жимсгэний талбай, хүлэмжид усны зарцуулалт багатай усалгааны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, хураалтыг механикжуулах;

6.3.8.Жимс, жимсгэний аж ахуй эрхлэгч болон үйлдвэрлэгчдийг танхимын, талбайн, ажлын байран дахь сургалтад хамруулж, харилцан туршлагыг нь солилцуулах арга хэмжээ авах

**6.4.“Салбарын маркетингийн стратегийг боловсруулж, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг тодорхойлох, шинэ зах зээлд нэвтрэх ажлыг эхлүүлэх” зорилтын хүрээнд:**

6.4.1.Хүн амд дотоодын жимс, жимсгэний бүтээгдэхүүнийг зохистой хэрэглэх дадал бий болгох, хэрэглээг нэмэгдүүлэх, ач тусыг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах;

6.4.2.Жимс, жимсгэнэ тариалагчид үйлдвэрлэсэн жимсээ чанар, стандартад нийцүүлэн зах зээлд гаргахад нь дэмжлэг үзүүлэх, борлуулалтын дотоод сүлжээг жимс, жимсгэнэ эрхлэгчдийн холбоотой хамтран бий болгох;

6.4.3.Хамгаалагдсан хөрсөнд нимбэг, жүрж, алим, интоор, бөөрөлзгөнө, гүзээлгэнэ зэрэг арвин ургацтай жимс жимсгэнэ тариалах санаачлагыг бүх талаар дэмжих, арга зүйгээр хангах.

6.4.4.Цэцэрлэг сургуулийн дотуур байр, эмнэлэг, сувиллын газрууд болон “Үдийн цай” хөтөлбөрийн хүрээнд дотоодын үйлдвэрлэлийн стандарт, чанарын шаардлага хангасан жимс, жимсгэнэ тэдгээрийг боловсруулсан бүтээгдэхүүнийг өргөн хэрэгжүүлэх

6.4.5.Жимс, жимсгэний тариалалт, хураасан ургацын тоо хэмжээг Хүнс, хөдөө аж ахуйн газрын болон статистикийн мэдээлэлд тусган бүртгэлжүүлэх

**Долоо: Хөтөлбөрийн санхүүжилт.**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

7.1.Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

7.2.Сум хөгжүүлэх сан

7.3.Засгийн газрын жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан

7.4.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

7.5.Олон Улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, тусламж, хөрөнгө оруулалт

7.6.Гадаад дотоодын төсөл хөтөлбөр.

### Найм: Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа

8.1 “Жимс, жимсгэнэ” хөтөлбөрийг 2018-2022 онуудад хэрэгжүүлнэ.

### Ес. Хүрэх үр дүн.

9.1.Жимс жимсгэний талбай 900 га талбайд хүрч, боловсруулах үйлдвэртэй болсноор шинээр ажлын байр бий болно.

9.2.Экологийн цэвэр бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээ нэмэгдэж аймгийнхаа хэрэгцээт жимс, жимсгэний 25 хувийг ханган, дотоодын хэрэгцээнээс гадна экспортод гаргах боломж бүрдсэн байна.

9.3.Экологийн нөхөн сэргээлт хийх, мод суулгац үржүүлэх, цэцэрлэгжүүлэлт, жимс жимсгэний аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа өргөжинө.

9.4.Жимс жимсгэний аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлтэй болсноор шинээр ажлын байр бий болно.

9.5.Байгалийн жимс жимсгэний талбайг хамгаалалтанд аван нөхөн сэргээж, байгалийн жимс жимсгэнийг зохистой ашиглах тогтолцоо бүрдэнэ.

9.6.Таримал жимс жимсгэний нэр төрөл нэмэгдсэнээр хүн ам аюулгүй, экологийн цэвэр жимс жимсгэнийг хүнсэндээ тогтвортой хэрэглэдэг болно.

### Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2017 он)	Зорилтот түвшин (2022 он)
1	Жимс, жимсгэнэ тариалах талбай	Га	794,2	900
2	Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаанд бэлтгэх ургацын хэмжээ	тонн	146,0	200,0
3	Бэлтгэсэн суулгац	мянган ширхэг	242775	300000
4	Дотоодын үйлдвэрлэлийн жимс, жимсгэний хангамж	Хувь	1,5	4,5
5	Экспортолсон бүтээгдэхүүний мөнгөн дүн	Сая. төг	730,0	1000,0
6	Жимс, жимсгэний кластер/өртгийн сүлжээ		-	Өртгийн сүлжээ үүссэн байна

Хөтөлбөр хэрэгжих хугацааны шалгуур үзүүлэлтүүдийн жил жилийн хүрэх түвшинг Хүнс, хөдөө аж ахуйн газар тооцон аймгийн Засаг дарга сумдын Засаг даргатай байгуулах гэрээнд тусган хэрэгжилтийг зохион байгуулж тайлагнана.